



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/710.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолын хүрээнд хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх, нийлүүлэлтийн зохиомол хомсдол болон үнийн зохиомол хөөрөгдлөөс сэргийлэх талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Жаргалсайхан- Аймгийн Засаг даргын орлогч

Ажлын хэсгийн

гишүүд: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,  
эрх зүйн хэлтсийн дарга, Шударга өрсөлдөөн,  
хэрэглэгчийн төлөө газрын орон нутаг  
дахь ахлах байцаагч

Г.Өөдэй- Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга,  
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын  
орон нутаг дахь байцаагч

Л.Гэрэлмаа- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,  
эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Шударга  
өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон  
нутаг дахь байцаагч

Г.Нэргүй - Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой  
байдлын газрын дэд дарга

Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Ц.Лувсанлхамо - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Н.Мөнхзаяа - Жаргалант сумын Мал эмнэлгийн улсын байцаагч

Ц.Нанжид - Жаргалант сумын Хүнс, хөдөө аж ахуйн  
тасгийн дарга

Нарийн бичгийн

дарга: О.Дарьжав- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний  
эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

2. Дээрх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион  
байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ, тайланг Хүнс, хөдөө аж ахуй,  
хөнгөн үйлдвэрийн яаманд тухай бүр хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч  
/Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ